



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

Хурлын Үр дүн

*НУБХХ-ДДБОС “Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн
байгалийн нөөцийн нэгдсэн менежмент” төсөл
<http://baikal.iwlearn.org>*

OХУ ба Монгол Улс

Удирдах Зөвлөлийн Бүсийн Гуравдугаар Хурал

Гремячинск, ОХУ

2014 оны 7-р сарын 24 өдөр

Хурлын дарга: Владимир О. Мамаев, НУБХХ/ДДБОС-гийн бүс нутгийн зохицуулагч
Нарийн бичиг: Англи – Борис В. Бадуев
Монгол – Төмөрчөдөр Содном
Орос – Лариса Д. Раднаева

Хурлын хөтөлбөр: [download](#)

Оролцогчдын нэрс: [download](#)

Илтгэл, тайлан, танилцуулга материал: <http://baikal.iwlearn.org/ru/proekt-1/rukovodyaschii-komitet/trete-zasedanie>

Удирдах Зөвлөлийн гуравдугаар хурлын зорилго :

Байгаль нуурын төслийн 2013 онд хийсэн ажлын тайлан, 2014 оны ажлын төлөвлөгөөг төсвийн хамт танилцуулах, Байгаль нуурын сав газрын Стратеги Уйл Ажиллагааны Хөтөлбөрийг танилцуулж, ОХУ ба Монгол Улсын хооронд хилийн усны нөөцийг ашиглах, хамгаалах салбарт олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлыг хэлэлцэх.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

Удирдах Зөвлөлийн Бүсийн Гуравдугаар Хурал ОХУ-ын Буриад Улсын Гремячинскт 2014 оны 7-р сарын 24-ний өдөр болов.

Хурлын нээлт

Владимир О. Мамаев хурлыг нээж хурлын зорилгыг оролцогчдод товч танилцуулав.

Оролцогчдыг угтан:

Төслийн Оросын Үндэсний Захирал, Холбооны Байгалийн Нөөцийн Хяналтын Албаны Дэд Захирал Амирхан М. Амирхановыг төлөөлж, Байгаль нуур төслийн Оросын техникийн захирал Александр А. Шеховцов;

Төслийн Монголын Үндэсний Захирал, БОНХЯ-ны Дэд Сайд Б.Тулгийг төлөөлж , Ус цаг уур, орчны хүрээлэнгийн Усны секторын эрхлэгч Г.Даваа;

Буриад Улсын Байгалийн Нөөцийн Яамны сайд Юрий П. Сафьянов;

Монгол улсын Засгийн Газрын Усны Үндэсний Хорооны дарга Ц.Бадрах;

Холбооны усны нөөцийн агентлаг, Енисей Мөрний Сав Газрын Усны Менежментийн Захиргааны орлогч дарга Малерий Молотов

нар үг хэлж мэндчилэв.

Төслийн үр дүн 2013 он

Энэ асуудлыг төслийн менежер Сергей В. Куделя танилцуулж, төслийн 2013 оны үр дүнгийн талаарх материалыг 2014 оны эхэнд Удирдах Зөвлөлийн гишүүн тус бүрт илгээж, түүнчлэн төслийн албан ёсны вэб хуудсанд тавьсныг ([download](#)) дурьдаж хэлэв.

Үүнээс гадна Сергей В. Куделя 2013 онд хийсэн ажил, гарсан зардлын талаар дэлгэрэнгүй танилцуулав.

Үүний дараа төслийн Орос дахь техникийн захирал Александр А. Шеховцов, Монгол дахь техникийн захирал С.Төмөрчөдөр нар төслийн хүрээнд 2013 онд ОХУ ба Монголын байгууллага, зөвлөхүүдийн хийсэн ажлын үр дүн нэг бүрээр нь дэлгэрэнгүй танилцуулав.

2013 онд гарсан үр дүнгийн талаар авч хэлэлцэх зүйл гараагүй ба УЗ санал нэгтэй хүлээн авсан.

Төслийн дунд шатны үнэлгээний Үр Дүн - [materials](#)

Энэ асуудлыг НҮБХХ/ДДБОС-гийн бүс нутгийн зохицуулагч Владимир О.Мамаев танилцуулав. Тэр оролцогчдод хандаж хэлэхдээ төслийн дунд шатны үнэлгээ нь төлөвлөгдсөн ажил байсан бөгөөд НҮБХХ/ДДБОС-гийн нэрийн дор хэрэгжиж буй бүх төслүүдийн хувьд зайлшгүй хийх ёстой ажлын нэг гэдгийг сануулж хэлэв.

Үүний дараа тэр 2014 оны 6-р сард УЗ-ийн гишүүн тус бүрт илгээсэн олон улсын бие даасан эксперт Жош Браны хийсэн дунд шатны үнэлгээний үр дүн ба өгсөн зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийв.

УЗ-ийн гишүүдээс санал шүүмжлэл байвал хурал дууссан өдрөөс эхлэн 14 хоногийн дотор төслийн багт ирүүлэхийг хүсэв.

Олон улсын бие даасан экспертын өгсөн зөвлөмж ([download](#)) тус бүрийн дагуу төслийн багаас хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг зөвшөөрч батлах саналыг Сергей В. Куделя УЗ-ийн гишүүдэд тавьсан.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

Төслийн дунд шатны үнэлгээтэй холбоотой асуудлыг ярилцаж, УЗ-өөс гаргасан санал шүүмжлэлийн дагуу хэлэлцээд дараах дүгнэлтийг хийж, шийдвэр гаргав. Үүнд:

- Төслийн дунд шатны үнэлгээг хүлээн авах;
- Үнэлгээтэй холбоотой санал шүүмжлэл, тайлбарыг төслийн багт 2 долоо хоногийн дотор илгээх;
- Олон улсын усны нөөцийн хамтын ажиллагааны хүрээнд ОХУ ба Монгол Улсын хооронд шинэ гэрээ байгуулах зайлшгүй шаардлагын талаар хөндсөн зөвлөмжөөс бусад зөвлөмжүүдийг нь дэмжин хүлээн авах. Удирдах Зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу төсөл шинэчилсэн гэрээний төсөл боловсруулж ОХУ, Монгол Улсын холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ба цаашид түүнийг хэлэлцэх асуудал Байгаль нуурын төслийн эрх мэдлийн хүрээнээс гадна байна (Энэ тухай хурлын хөтөлбөрт тусгагдсан “ОХУ ба Монгол Улсын хооронд хилийн усны нөөцийг ашиглах, хамгаалах хүрээнд олон улсын хамтын ажиллагааг сайжруулах нь” хэсэгт дэлгэрэнгүй авч хэлэлцэх болно).
- Зөвлөмжид тусгагдсаны дагуу Монголын талд явуулах төслийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх, тухайлбал Хөвсгөл нуур-Эг гол, Идэр голын сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих
- Байгаль орчныг хамгаалах салбарт ОХУ ба Монгол Улсын хамтын ажиллагааны 20 жилийн ойд зориулан олон улсын конференц зохион байгуулах санаачлагыг дэмжих.

Стратеги Үйл Ажиллагааны Хөтөлбөр (CYAX) боловсруулах ажлын явцын талаар

CYAX-ийн төслийг Англи, Монгол хэл дээр хэвлэн УЗ-ийн бүх гишүүдэд хурал эхлэхээс 2 долоо хоногийн өмнө тараасан болно.

CYAX-ийг боловсруулах ажлын шалгаруулалтанд орж сонгогдон энэ ажлыг ахлаж байгаа олон улсын зөвлөх Пол Гремилион CYAX боловсруулах үйл явц ба үе шат болон Байгаль нуурын ХДОДШ-тэй холбогдож байгаа шижим, түүнчлэн цаашид хийх ажлын тухай танилцуулав.

Тэр цааш нь CYAX-ийн зөвлөхүүдийн тодорхойлон гаргаж ирсэн CYAX-ийн бүтэц, зорилго ба хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар дэлгэрэнгүй ярив.

Хоёр орон зөвшөөрч гарын үсэг зурсан CYAX нь түүнийг хэрэгжүүлэх зорилгоор ДДБОС-гаас нэмэлт хөрөнгө олгох үндэс ба НҮБХХ-ийн дараагий төслийн эхлэл болох тухай В.О. Мамаев цохон тэмдэглэв.

Бусад улс орнуудад хэрэглэж байгаа CYAX-ийг боловсруулах стандарт, ялангуяа түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн үнэлгээний асуудал чухлыг В.С.Молотов тэмдэглэн хэлэв.

CYAX боловсруулах хугацаа нь хэт богино байсан, холбогдох яам, байгууллагуудад танилцуулж санал авах болон зөвлөхүүд нэмж авах шаардлагатай байгаа тухай УЗ-ийн гишүүд тэмдэглэн хэлсэн.

CYAX боловсруулах зардал мөнгө болон хугацаа хангалтгүй байсан тухай асуудалтай Сергей В. Куделя санал нийлж, 2015 оны төсвийн компонентийг өөрчлөн хуваарилах ба CYAX боловсруулах хугацааг доод тал нь 2015 оны 6 сар хүртэл сунгах шаардлагатай байгаа нэмж талаар хэлэв.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



Empowered lives.
Resilient nations.

СҮАХ боловсруулах болон зөвөлгөө авах ажлын явцад цаашид СҮАХ-ийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тодруулахын чухлыг УЗ-ийн гишүүд цохон тэмдэглэв. Байгаль орчныг хамгаалах Орос-Монголын хамтарсан комиссийг хэрэгжүүлэх механизмын нэг хувилбар байж болно гэж үзэв.

СҮАХ-ийн талаар өрнөсөн төрөл бүрийн асуудлыг дугуй ширээний ярилцлагын үеэр хэлэлцэн дараах дүгнэлт хийж, шийдвэрийг гаргав. Үүнд:

1. УЗ-ийн гишүүд СҮАХ-ийг боловсруулах явцыг дэмжин түүнийг эцэслэн дуусгасны дараа санал шүүмжлэл болон зөвөлгөө авахаар улс орнуудад өгөхийг санал болгоходо стратеги үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийн талаар хэлэлцэх;
2. СҮАХ-ийг эцэслэн боловсруулах ажлыг дуусгахад зориулж нэмэлт санхүүжилт гаргах үүднээс төслийн 2015 оны төсвийг хянан үзэхийг төслийн менежер Сергей В. Куделяд даалгах;
3. СҮАХ-ийг боловсруулах хугацааг 2015 оны 6-р сар хүртэл сунгах;

Хилийн усны нөөцийг ашиглах, хамгаалах хүрээнд ОХУ ба Монгол Улс хоорондын олон улсын харилцааг сайжруулах.

ОХУ ба Монгол Улсын хооронд хилийн усны нөөцийг ашиглах, тогтвортой хөгжүүлэх талаар хамтын ажиллагааны эрх зүй ба институцийн өнөөгийн байдлын тухай олон улсын эрх зүйч, хуулийн зөвлөх Сергей В.Виноградов дүгнэн танилцуулж, сайжруулах хувилбарыг санал болгов. Түүнчлэн УЗ-ийн бүсийн 2-р хуралдааны шийдвэрийг биелүүлэх үргийн дагуу боловсруулсан ОХУ ба Монгол Улсын ЗГ-ын хооронд хилийн усиг хамгаалах, тогтвортой хөгжүүлэх талаар хамтран ажиллах тухай Гэрээний төслийн гол бүлгүүд дээр тэр тогтон танилцуулав.

Сергей В.Виноградовын уг хэлсний дараа ОХУ-ын Байгалийн нөөц ба экологийн яамны (ОХУ-ын Минприрод) олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн төлөөлөгч Абидат М.Магомедова энэ асуудлаар дараах байр суурийг илэрхийлэв:

- ОХУ, Монгол Улсын ЗГ-ын хооронд байгуулсан Байгаль орчны талаар хамтран ажиллах тухай 1994 оны 2 сарын 15-ны өдрийн гэрээг (цаашид-гэрээ гэх) хэрэгжүүлэх зорилгоор 2013 оны 10 сарын 28-ны өдөр ОХУ-ын Байгаль орчны Яаманд Орос-Монголын хамтарсан комиссийн (цаашид-комисс) гуравдугаар хуралдаан болсон. Улзалтын үр дүнд Комиссийн хурлын Протоколд гарын үсэг зурсан. ОХУ-ын ЗГ-ын 1997 оны 5 сарын 7 өдрийн 551-р тогтоолын дагуу Комиссийн даргаар Оросын талыг төлөөлж Росприроднадзорын орлогч дарга А.М.Амирханов томилогдсон.
- Орос, Монголын ЗГ хооронд хилийн усиг хамгаалах, ашиглах талаар 1995 оны 2 сарын 11-ний өдөр байгуулсан гэрээг (цаашид - гэрээ) хэрэгжүүлэх талаар Орос-Монголын хоёр талын хамтын ажиллагааны журмыг Гэрээгээр тогтоож, түүнийг хэрэгжүүлэх механизм – талуудын ЗГ-ын Бүрэн Эрхт Институтийг үсгэн байгуулж, Бүрэн Эрхт ба түүний ажлын хэсгээс хилийн усиг хамгаалах, ашиглах талаар хуралдах, хамтран ажиллах журам гаргасан.
- Талуудын ЗГ-ын Бүрэн Эрхтийн үйл ажиллагаа нь норматив-эрх зүйн үндэс, талуудын бүтэц зохион байгуулалт-техник ба санхүү нь төрийн дэмжлэгээр хангагдсан тул Орос-Монголын хилийн усны объектыг хамгаалах, зохистой ашиглахад чиглэсэн асуудлыг боловсруулах, шийдэхэд шаардагдах хангалттай нөхцөлийг бүрдүүлсэн. Гэрээний төслийн 5 зүйлд зааснаар Орос-Монгол хоёр талын хилийн усны талаарх хамтын ажиллагааг хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний хүрээнд Талууд хэрэгжүүлнэ;

- Дээр хэлсэний дагуу хүчин төгөлдөр үйлчилж байгаа Орос-Монголын ЗГ хоорондын гэрээнүүд, түүний дотор Оросын Минприрод ба Усны нөөцийн Холбооны Агентлаг амжилттай хэрэгжүүлж буй ОХУ ба Монгол Улсын ЗГ-ын хооронд байгуулсан Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай 1994 оны 2 сарын 15-ний өдрийн, мөн Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай 1995 оны 2 сарын 11-ний өдрийн гэрээнүүдэд өөрчлөлт оруулах нь зохижгүй гэж үзэж байна;
- Тиймээс ОХУ ба Монгол Улсын ЗГ-ын хооронд Хилийн усыг хамгаалах, тогтвортой хөгжүүлэх талаар хамтран ажиллах тухай танилцуулсан Гэрээний төслийг цаашид авч хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байна.

Энэ асуудлаар Монгол Улсын БОНХЯам дараах байр суурийг илэрхийлэв. Үүнд:

- Хилийн усны нөөцийг ашиглах, хамгаалах тухай Орос-Монгол Улсын Засгийн Газрын хооронд 1995 оны 2-р сарын 11-ний өдөр байгуулсан гэрээг хоёр тал үр бүтээлтэй хэрэгжүүлж байгаа ба түүнийг эргэж хянах, шинэчлэх шаардлагагүй гэж үзэв;
- Одоогоор хэрэгжиж байгаа Бүрэн Эрхтийн механизм нь хоёр талын өнөөгийн үүрэг, зорилгод нийцэж байгаа тул комисс гэх мэт шинэ механизмыг байгуулах шаардлагагүй гэж үзэж байна.

Дараагийн дугуй ширээний ярилцлагын үеэр доорх шийдвэрүүдийг гаргасан болно:

- ОХУ-ын Минприрод болон Монгол Улсын БОНХЯ-ны байр суурийг хүлээн авах;
- ОХУ ба Монгол Улсын ЗГ-ын хооронд хилийн усыг хамгаалах, тогтвортой хөгжүүлэх талаар хамтран ажиллах тухай Гэрээний төслийг Худалдаа-эдийн засаг ба шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Орос-Монголын ЗГ-ын хоорондын комисст шилжүүлэн өгч гэрээг боловсруулахтай холбоотой бүх ажлыг Байгаль нуурын төслийн хүрээнд зогсоох;
- Хоёр талын хүсэлтийн дагуу одоо үйлчилж байгаа гэрээний хүрээнд ОХУ ба Монгол Улсын хооронд хилийн усны нөөцийг хамгаалах тогтвортой хөгжүүлэх, хууль эрх ба институцийн бүтцийг сайжруулах чиглэлээр олон улсын экспертээр дамжуулан зөвлөлгөө өгөх.

2014 оны ажлын төлөвлөгөө ба төсөв

2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангийн хамт 2014 оны ажлын төлөвлөгөөг УЗ-ийн гишүүн тус бүрт 2014 оны эхэнд ([download](#)) хүргүүлсэн тухай төслийн менежер С.В.Куделя өөрийн илтгэлийн өмнө оролцогчдод сануулан хэллээ. Үүнээс гадна хоёр улсын ЗГ-ын гарын үсэг зурсан төслийн баримт бичигт тусгагдсан төсвийн дагуу ямар нэгэн мэдэгдэхүйц хазаалтгүйгээр сайн нийцэж явааг С.В.Куделя дурьдан хэлэв. Өнөөдрийн хурал болон CYAX боловсруулах явцад гарах зөвлөмжүүдийг харгалзан үзсэн 2015 онд хийх ажлын төлөвлөгөөг 2015 оны эхээр УЗ-ийн гишүүн тус бүрт батлуулахаар хүргүүлэх болно.

Цааш нь Сергей В. Куделя 2014-2015 оны (Хүснэгт 1) ([download](#)) ажлын төлөвлөгөө ба төсвийг танилцуулав.

Төслийн Үр дүн	Нийт төсөв (ам.доллар)	Зардал 2011+2012	Зардал 2013	Төлөвлөсөн төсөв 2014	Төлөвлөсөн төсөв 2015

Үр дүн 1: Стратеги ба бодлого төлөвлөлтийн үндэс



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



*Empowered lives.
Empowered nations.*

	\$ 917 930.00	\$ 486 312.97	\$ 292 882.27	\$ 109 425	\$ 29 309.76
--	---------------	---------------	---------------	------------	--------------

Үр дүн 2: Усны Нөөцийн Нэгдсэн Менежментийн Институцийг бэхжүүлэх

	\$ 751 534.00	\$ 242 852.27	\$ 218 659.92	\$ 184 500	\$ 105 521.81
--	---------------	---------------	---------------	------------	---------------

Үр дүн 3: Усны чанар, биологийн төрөл зүйлийн менежментийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга, аргачлалыг нэвтрүүлэх

	\$1 844 174.00	\$ 202 329.09	\$ 517 112.47	\$ 623 080	\$ 501 652.44
--	----------------	---------------	---------------	------------	---------------

Төслийн менежмент	\$ 384 362.00	\$ 102 990.12	\$ 98 744.84	\$ 92 210	\$ 90 417.04
----------------------	---------------	---------------	--------------	-----------	--------------

Нийт	\$3 898 000.00	\$1 034 484.45	\$1 127 399.5	\$ 1 009 215	\$ 726 901.05
------	-----------------------	-----------------------	----------------------	---------------------	----------------------

Хүснэгт 1. Төслийн төсөв ба зардал.

Илтгэлийн төгсгөлд Владимир Мамаев 2014 оны ажлын төлөвлөгөө болон төсөв хэлэлцэх санал тавив.

Хэлэлцүүлгийн үеэр Хөвсгөл нуур-Эг ба Идэр голын сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дамжих, түүнчлэн Буриадын нутаг дэвсгэрт уул уурхайн салбарт Оросын байгууллагуудын хэрэгжүүлсэн загвар төслүүдийн үр дүнгээс Монголын талтай хуваалцах нь чухал ач холбогдолтой байна гэж УЗ-ийн Монгол талын гишүүд үзлээ.

Үүний зэрэгцээ УЗ-ийн Монгол талын гишүүд Монгол улсад загвар төслүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг олох боломжийг судлаар зөвлөсөн.

Түүнчлэн Монголын НҮБХХ-өөс Монголд хэрэгжүүлж байгаа төслүүд нь үйл ажиллагааны төсөв бүрээр ТУЗ-ийн гишүүдтэй зөвшшилцдөг ба энэ нь жилийн төлөвлөлтөнд илүү нарийн дүн шинжилгээ хийх боломжтой байдгийг онцгойлон дурьдлаа.

Сергей В.Куделя төсөл хэрэгжүүлэх нэгж нь үйл ажиллагаагаа явуулахдаа бүсийн НҮБХХ ба НҮБТҮА гаргасан жилийн төлөвлөлт хийх ба тендер зохион байгуулах дүрэм журмыг хатуу дагаж мөрддөг болохыг мэдэгдсэн.

Цааш нь төслийн дунд шатны үнэлгээ хийсэн олон улсын бие даасан экспертийн өгсөн зөвлөмжүүдийн нэг нь төслийн хугацааг нэмэлт санхүүжилт хийлгүйгээр 2015 оны сүүл хүртэл сунгах тухай байсныг С.В.Куделя сануулж хэлэв. Төслийн менежментийн баг энэ зөвлөмжийг дэмжиж байгаа ба УЗ-өөс энэ саналыг дэмжихийг хүсэв. УЗ-ийн гишүүд татгалзсан хариу өгөөгүй.

Төслийн дунд шатны үнэлгээ хийсэн олон улсын бие даасан зөвлөхийн өгсөн саналын дагуу С.В.Куделя өөрчлөлт оруулах саналын төслийг танилцуулав.

Өөрчлөх санал 1:

Хуудас 67 – Стратеги үр дүнгийн бүтэц



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



UNOPS



*Empowered lives.
Resilient nations.*

Бохирдлын халуун цэгүүд дэх мониторингийн талбайн бохирдлын түвшин	Халуун цэгүүд дэх газар нутагт мөнгөн ус, уурхайн бусад бохирдуулагчийн нэмэгдэж байгаа түвшин	Төсөл дуусахад зорилтот газар нутагт багадаа 20% буурсан байна.	Хээрийн хяналтын үр дүн	Мөнгөн усыг орлуулан хэрэглэх талаар сургалт хийсний дараа ч Мөнгөн усыг Ургэлжлүүлэн ашиглах магадлалтай.
--	--	---	-------------------------	--

Өөрчлөлтөнд өгөх санал:

Сонгон авсан объектын хувьд ч бохирдлын түвшин 20 хувиар буурсан гэдгийг бодитоор харуулж чадахгүйн улмаас энэ шалгуурыг хасах.

Санал 1-ийн талаар гаргасан шийдвэр: УЗ-ийн бүх гишүүд энэ өөрчлөлттэй санал нэг байв, гэсэн хэдий ч энэ шалгуур нь дэлхий нийтийн ач холбогдолтой учраас зөвхөн ДДБОС зөвшөөрсөн тохиолдолд хасах боломжтой тухай В.О.Мамаев тэмдэглэн хэлэв. Энэ шалгуур үзүүлэлтийг хасах боломжийн талаар төслийн менежер С.В.Куделя НҮБХХ болон ДДБОС-тай ярих ёстай.

Өөрчлөх санал 2:

Хуудас 78 – Стратеги үр дүнгийн бүтэц

	Шалгур	Үндэслэл	Зорилт	Нотлох эх үүсвэр
Үр дүн 2: УННМ-ийн Институцийг чадавхижуулах	Байгаль нуурын сав газрын хамтарсан комиссийн эрх зүйн статусыг Орос ба Монголын ЗГ сунгана/сунгахгүй.	Хилийн усыг ашиглах Орос-Монголын хамтарсан шуурхай хэсэг хуулийн этгээд биш.	Орос ба Монголын хуулиар үйл ажиллагааны 3 дах жилийн сүүлээр эрх зүйн статустай болсон.	Гэрээний санамж бичгийг батлаж, бүтэц зохион байгуулалтын статусын баримт бичгийг хянан узсэн.
	Хамтарсан комиссийн орон тооны гүйцэтгэх захирал томилогдсон/томилог доогүй.	Шуурхай хэсэг орон тооны захирал байхгүй.	4 дэх жилдээ тодорхойлсон.	Орос ба Монголын холбогдох байгууллагуудын томилгоо.

Өөрчлөлтөнд өгөх санал:

Улс орнуудаас тавих шаардлага өөрчлөгдсөний дагуу стратеги үр дүнгийн бүтцийн энэ хоёр шалгуурыг дараах байдлаар нэгтгэн өөрчлөх:

Зорилго/Бүрэлдэхүүн/Үр дүн	Шалгур	Үндэслэл	Зорилт	Нотлох эс үүсвэр
Үр дүн 2: УННМ-ийн институцийг чадавхижуулах	Хилийн усны сав газрыг хамгаалах, тогтвортой хөгжүүлэх тухай Орос ба Монголын ЗГ-ын хамтын ажиллагааны гэрээ	Хилийн усыг ашиглах Орос-Монголын хамтарсан ажлын хэсэг нь хуулийн этгээд биш.	Гэрээг 3 дах жилийн эцсээр шинчилсэн бөгөөд улсууд зохих зөвлөгөөг авсан.	Холбогдох агентлагуудын албан бичиг. Засгийн Газар хоорондын хурлын тэмдэглэл.

Санал 2-ын талаар гаргасан шийдвэр:

ДДБОС-тай зөвшөлцсөний дараа гэсэн тайлбартайгаар УЗ-ийн бүх гишүүд энэ саналыг дэмжив. Энэ шалгуурыг өөрчлөх боломжийн талаар НҮБХХ ба ДДБОС-тай ярилцах ажлыг төслийн менежер С.В.Куделяд үүрэг болгов.

Өөрийн илтгэлийн төгсгөлд Сергей Куделя 2015 онд төсөл хэрэгжүүлэх үйл явцын гол чухал хугацааг хэлэлцүүлэхээр танилцуулав:

- **2015 оны 1 сар** – 2014 оны үр дүнгийн танилцуулга; 2015 оны ажлын төлөвлөгөө ба төсвийг батлах.
- **2015 оны 7-8 сар** – Төслийн УЗ-ийн сүүлчийн хурал;
- **2015 оны 9 сар** – Төслийн эцсийн үнэлгээ;
- **2015 оны 10-11 сар** – Төслийн хаалт.

УЗ-ийн гишүүдээс татгалзах санал гараагүй.

Хурлын хаалт ба гарсан шийдвэр:

Тавьсан илтгэлүүд, ирүүлсэн мэдээ материал болон ярилцлага хэлэлцүүлэгт тулгуурлан төслийн УЗ-өөс дараах шийдвэрийг гаргав:

1. Төслийн 2013 онд хүрсэн үр дүнг авч үзэх.
2. Төслийн УЗ-ийн гишүүд CYAX боловсруулж буй үйл явцтай танилцаж, CYAX-ийн эцслэн боловсруулсан төслийг улс орнуудад санал шүүмж болон зөвлөгөө авахаар өргөн барихдаа стратеги үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийн талаар хэлэлцэхийг дэмжих.
3. CYAX боловсруулах хугацааг 2015 оны 6 сар хүртэл сунгаж, CYAX-ийг эцслэн дуусгах ажлыг амжилттай гүйцэтгэхэд зориулж нэмэлт санхүүжилт гаргах зорилгоор төслийн 2015 оны төсвийг хянан үзэхийг төслийн менежерт даалгах.
4. Хилийн усны нөөцийг ашиглах, хамгаалах чиглэлээр хамтран ажиллах тухай шинэ гэрээний төслийг цаашид боловсруулах шаардлагагүйяячя гэж үзсэн ОХУ-ын Байгалийн Нөөц ба Экологийн Яам болон Монгол Улсын БОНХЯамны байр суурийг анхаарч үзэх.
5. ОХУ ба Монгол Улсын ЗГ-ын хооронд хилийн усны нөөцийг ашиглах, тогтвортой хөгжүүлэх талаар хамтран ажиллах тухай боловсруулсан гэрээний төслийг ОХУ ба Монголын Улсын Засгийн газар хоорондын Худалдаа-эдийн засаг ба шинжлэх ухаантехникийн хамтын ажиллагааны комисст шилжүүлэн өгч гэрээг боловсруулахтай холбоотой бүх ажлыг Байгаль нуурын төслийн хүрээнд зогсоох.
6. Одоо байгаа бүтэц ба механизмыг, тухайлбал хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Орос, Монголын ЗГ-ын хооронд 1995 онд байгуулсан гэрээг биелүүлэх хүрээнд Бүрэн эрхт болон тэдний ажлын хэсгийн уулзалт, зөвлөгөөн хийх түүнчлэн хүрээлэн буй орчны талаар хамтран ажиллах ОХУ, Монгол улсын ЗГ-ын хооронд байгуулсан гэрээг хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх.
7. Төслийн дунд шатны үнэлгээний дунг хүлээн авах. Санал, шүүмжлэлээ төслийн багт хоёр долоо хоногийн дотор хүргүүлэх.
8. Төслийн дунд шатны үнэлгээ хийсэн олон улсын бие даасан экспертээс гаргасан олон улсын усны нөөцийн салбарт ОХУ ба Монгол Улсын хооронд шинэ гэрээ байгуулах шаардлагатай гэсэн агуулга бүхий зөвлөмжөөс бусад зөвлөмжийг хүлээн авах.
9. Монголын талд явуулах төслийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тухайлбал Хөвсгөл нуур-Эг гол, Идэр голын сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих талаарх зөвлөмжийг хүлээн авах
10. Байгаль орчныг хамгаалах салбарт ОХУ ба Монгол Улсын хамтын ажиллагааны 20 жилийн ойд зориулан олон улсын конференц зохион байгуулах санаачлагыг дэмжих.
11. УЗ-ийн гишүүдийн гаргасан зөвлөмжийн дагуу сайжруулан зассан ажлын төлөвлөгөө ба 2014-2015 оны төсвийг ерөнхийд нь батлах.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



International
Hydrological
Programme



*Empowered lives.
Resilient nations.*

12. Дээр дурьдсан төслийн бичиг баримтанд оруулсан хоёр өөрчлөлтийг батлах санал тавих.
13. УЗ-ийн гишүүд баримт бичигт өгөх саналаа хурал дууссаны дараа 2 долоо хоногийн дотор төслийн багт өгөх.
14. УЗ-ийн бүсийн 4 дүгээр хуралдааныг 2015 оны 7-8 сард зохион байгуулах.
15. Байгаль нуурын төслийн эцсийн үнэлгээг 2015 оны 9-р сард хийх.